МЭДЭЭ · 2022 оны 11-р сарын 21

ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС АРХАНГАЙ АЙМАГТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Тээврийн прокурорын газраас Тээврийн цагдаагийн алба, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газрын Авто техникийн шинжилгээний лаборатортой хамтран сургалт зохион байгууллаа.

Сургалтыг "Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, мэдүүлэг авах ажиллагаанд анхаарах асуудал" сэдвийн хүрээнд явуулсан бөгөөд аймгийн прокурор, цагдаагийн газрын мөрдөгч, прокурорууд хамрагдсан байна.